



**ТОНОГ
ТӨХӨӨРӨМЖИЙН
ЗЭЭЛ**

Зээлийн танилцуулга

Бизнесийн үйл ажиллагаандаа ашиглах зорилгоор бүх төрлийн тоног төхөөрөмж (үйлдвэрлэлийн болон хүнд даацын техник, машин механизм) худалдан авахад зориулагдсан зээл.

Зээлийн нөхцөл

Зээлийн хэмжээ	Тоног төхөөрөмжийн үнийн дүнгийн 70% буюу хамгийн багадаа 50.0 сая төгрөг, түүнтэй тэнцэх валют
Зээлийн хүү /жилийн/	Төгрөг : 18.0% - 22.8% Ам. Доллар : 15.6% - 20.4%
Зээлийн хугацаа	Суурьлагдах боломжтой үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж 48 сар хүртэл Суурьлагдах боломжтой үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөс бусад тоног төхөөрөмж 36 сар хүртэл
Зээлийн үйлчилгээний шимтгэл	0.5% (5.0 тэрбум MNT болон түүнээс дээш-0.3%)
Зээлийн барьцаа	Зээлээр санхүүжүүлэх тоног төхөөрөмж (Шаардлагатай тохиолдолд нэмэлт барьцаа шаардана.)
Даатгал	Зээлээр санхүүжүүлэх тоног төхөөрөмж, машин механизмыг эд хөрөнгийн даатгалд хамруулсан байх

Бүрдүүлэх бичиг баримт

Иргэний хувьд
- Зээлдэгч, хамтран зээлдэгч тус бүрийн Зээлийн хүсэлт Иргэн (Маягт 068); - Нотариатаар баталгаажуулсан иргэний үнэмлэхийн хуулбар (зээлийг хамтран хариуцах хүнд мөн адил хамаарна); - Үйл ажиллагаа явуулах лиценз, зөвшөөрөл;

- Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, газар өмчлөх эрхийн гэрчилгээ, газар эзэмших гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, шаардлагатай бол итгэмжлэл (эх хувь);
- Орлогын бүртгэлийн дэвтэр (хар дэвтэр), байгаа бол аж ахуйн нэгжийн сүүлийн нэг жилийн санхүүгийн тайлан;
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцлүүд;
- Орлого, зардал, өглөг, авлага, санхүүжилтийг нотлох анхан шатны баримтууд;
- Гэрлэлтийн гэрчилгээ (гэрлээгүй бол гэрлэсэн эсэх лавлагаа);
- Бусад шаардлагатай бичиг баримтууд

Хуулийн этгээдийн хувьд

- Зээлийн хүсэлт -Байгууллага (маягт 069)
- Санхүүгийн баримтад гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн мэдээлэл(Маягт 070)
- Улсын бүртгэлийн гэрчилгээ
- Компанийн дүрэм
- Санхүүгийн тайлан /сүүлийн 1 жил/
- Үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл, лиценз
- Зээл авах, компанийн үл хөдлөх хөрөнгийг барьцаанд тавихыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоол (ТУЗ);
- Барьцаа хөрөнгийн гэрчилгээ, газар өмчлөх эрхийн гэрчилгээ, газар эзэмших гэрчилгээ, гэрээ, кадастрын зураг, шаардлагатай бол итгэмжлэл (эх хувь).
- Бизнесийн үйл ажиллагаатай холбоотой гэрээ хэлцлүүд;
- Орлого, зардал, өглөг, авлага, санхүүжилтийг нотлох анхан шатны баримтууд;
- Байгаль, орчин нийгмийн хариуцлагатай холбоотой баримт, материал;
- Зээлийн зарцуулалттай холбоотой бичиг баримтууд;
- Бусад шаардлагатай бичиг баримтууд.

Тоног төхөөрөмжийн хувьд

- Худалдах, худалдан авах гэрээ эсвэл нэхэмжлэх;
- Тоног төхөөрөмжийн тодорхойлолт;
- Тоног төхөөрөмжийн хүчин чадал, чанар байдлын тухай мэдээлэл;
- Хуучин ашиглагдаж байсан хөдлөх тоног төхөөрөмж, техник, машин механизмын хувьд тээврийн хэрэгслийн гэрчилгээтэй бол гэрчилгээний хуулбар;
- Суурилагдах болон үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжийн хувьд техникийн паспорт эсвэл үйлдвэрлэлийн гэрчилгээтэй бол хуулбар;
- Гадаадаас орж ирсэн, шинэ тоног төхөөрөмжийн хувьд гаалийн баримт бичиг.



ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЛИЙГ:

Утас: +976 1800-1977

И-мэйл: info@tdbm.mn

Вэб хаяг: www.tdbm.mn